

## Баялгийн засаглал, менежмент: Ботсвана улсын туршлага



Ботсвана нь хүн ам тархаж суурьшсан, далайд гарцгүй, хагас хуурай уур амьсгалтай, нийт 582,000 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй Өмнөд Африкийн улс юм. Газар зүйн шинж чанараараа Монголтой төстэй. Ботсванагийн хүн амын тоо 2011 онд 2 сая, ихэнх хэсэг нь нутгийн зүүн хэсгээр суурьшдаг. Нутгийн баруун өмнөд хэсгийн ихэнх талбайг Kalahari цөл эзэлдэг, ашигт малтмалын нөөц, ялангуяа алмаз буюу очир эрдэнийн нөөц арвинтай.

Ботсвана нь 1966 онд дэлхийн хамгийн ядуу улс орноор тооцогддог байсан үедээ тусгаар тогтнолоо тогтоосон. Тухайн үед нэг хүнд ногдох ДНБ нь 90 ам.доллар байсан бөгөөд НҮБ-ийн ангиллаар буурай хөгжилтэй орны тоонд ордог байв. Тус улс нь 1965 оны байдлаар дэд бүтэцгүй, нийт засмал замын урт нь зөвхөн 12 км, үндсэндээ нийслэл хот байхгүй, засгийн газрын ямар нэгэн ордон байргүй, төрийн үйлчилгээний тоо нь маш хязгаарлагдмал, эрүүл мэнд, болосвролын үзүүлэлт тааруу, нийт 22 иргэн их дээд сургуулийн боловсролтой, зөвхөн 100 хүн дунд сургуулийн боловсролтой байсан байна.

1967 онд илрүүлсэн алмазын орд нь эрчимтэй хөгжлийн үүдийг нээсэн бөгөөд энэ улс нь 2011 онд нэг хүнд ногдох ДНБ нь 9,537 ам.доллартай тэнцэж, дундаас дээш орлоготой улс орны тоонд багтдаг болсон. 1966-2013 онуудад эдийн засгийн өсөлтийн дундаж түвшин нь жилийн 9 хувь байна. Гэхдээ Дэлхийн санхүүгийн хямралын улмаас 2007 онд 8.7 хувь, 2009 онд -7.8 хувьтай байсан байна. Сүүлийн жилүүдэд өсөлтийн түвшин 5.5 орчим хувьтай байна.

Өнөөдөртус улс дундаас дээш орлоготой орон болж өөрчлөгдсөн бөгөөд эдийн засгийн хөгжил, нийгмийн салбарын дэвшлийг хангахад өөрийн улсын ашигт малтмалын орлогыг дараах арга замуудаар удирдан зохион байгуулсан байдаг. Үүнд:

- зохицуулах бодлогуудын тогтвортой байдал болон урьдчилан харж болохуйц байдал, үүнд татварын асуудал хамаарна;
- сайн засаглал, ил тод байдал, авилгын хэмжээг хамгийн бага түвшинд байлгах;
- төр болон хувийн хэвшлийн ашиг сонирхлыг улс орны том эдийн засгийн ашиг тусын тулд нийцүүлэх;
- ашигт малтмалаас олсон орлогоо биет хөрөнгө, боловсрол, сургалт, эрүүл мэндийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийхэд зориулах;
- мөчлөгийн-эсрэг төсвийн зарцуулалт, ингэснээр байгалийн баялгийн орлогын хэлбэлзлээс хамаарахгүйгээр Засгийн газрын зардлыг жигд байлгах;
- төсвийн зардлын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох үйл явц ил тод байх;
- дотооддоо нэмүү өртөг бий болгох, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, туршлагыг нэмэгдүүлэх юм.

Ботсванагийн эдийн засгийн нийт нэмүү өртгийн үйлдвэрлэлийн дөрөвний нэг хувийг уул уурхайн салбарын үйлдвэрлэл бий болгодог. Барилгын салбар болон ялангуяа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ өссөнөөр уул уурхайн салбарын нэмүү өртгийн үйлдвэрлэлд эзлэх хувь нь 2000 онд 37 хувь байсан бол 2012 онд 22 хувь болж буурсан. Дэлхийн санхүүгийн хямралын улмаас уул уурхайн үйлдвэрлэлийн хэмжээ 2009 онд 46 хувиар хумигдсан бөгөөд энэ нь улсын эдийн засаг дэлхийн алмазын болон бусад түүхий эдийн зах зээл дэх эрэлтээс ихээхэн хамааралтай байгааг харуулсан. Ботсвана нь мөн түүнчлэн нүүрс, зэс/никель, алт, soda ash олборлодогоос гадна өөр бусад түүхий эдийн нөөц тогтоогдсон. Засгийн газраас нүүрс, зэс, мөнгө зэргээр түүхий эдийн нэр төрлийг олшруулах чиглэл баримталдаг. Алмаз, зэс, никелийн 6 тэрбум ам.долларын экспорт 2012 онд нийт экспортын 80-аас дээш хувийг эзэлж байсан. Үүнээс алмазын экспорт 4.7 тэрбум ам.доллар байв.

Ботсванагийн байгалийн баялгийн менежментийн давуу талууд нь:

**Зохицуулалтын бодлого нь тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой.** Капиталын хөрөнгө оруулалт ихээр шаарддаг олборлох салбарын хувьд татварын бодлого ихээхэн чухал нөлөөтэй. Ботсванагийн хувьд татварын талаарх хууль дүрэм нь тогтвортой, аливаа өөрчлөлтийг үе шаттайгаар авч хэрэгжүүлдэг.

**Сайн засаглал, ил тод байдал.** Ботсвана нь эдгээр үзүүлэлтээрээ олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн. Уул уурхайн салбарын үр өгөөжийг ашиглан нийт эдийн засгийн хөгжлийг хангахад төр болон хувийн хэвшлийн ашиг сонирхлыг уялдуулж чадсан. Урт хугацаанд байгуулагдсан De Beers S.A. болон Ботсванагийн Засгийн газрын хамтарсан компани нь Ботсванад олборлож буй түүхий эдээ эзэмшихийн зэрэгцээ дэлхийн хэмжээний нэр хүнд бүхий компаниас олон чиглэлийн менежментийн болон компанийн стратегийн ур чадварыг ашиглан хөгжих боломжийг олгосон.

**Хөрөнгийг орлуулах зарчмыг баримтлах:** нөхөн сэргээгдэхгүй нөөцөөс олсон орлогоор бусад хөрөнгөд санхүүгийн хөрөнгө оруулалт хийх; энэхүү орлогыг засгийн газрын урсгал зардлыг санхүүжүүлэхэд ашигладаггүй (энэ урсгал зардлыг зөвхөн урсгал орлогоор санхүүжүүлдэг). Сүүлийн 30-аад жилд түүхий эдийн нөөц ашиглалтын орлогыг дан ганц биет капиталын хөрөнгө оруулалт болон хүний нөөцөө чадавжуулахад бүрэн зориулсан. Үүний 44 хувь нь биет хөрөнгө, 42 хувь боловсрол ба сургалт, 14 хувь нь эрүүл мэндийн салбарт зориулагдсан.

**Мөчлөгийн эсрэг төсвийн зардлын зарчмыг** хэрэгжүүлснээр түүхий эдийн зах зээлийн үнэ өндөр байх үеүдэд орлогоос хуримтлал бүрдүүлж, үнэ буурсан үед түүнийгээ ашиглан засгийн газрын зардлын түвшинг зүй зохистой тогтвортой байлгадаг. Түүхий эдийн орлогоос зарцуулагдаагүй үлдсэн хөрөнгийг урт хугацааны хөрөнгө оруулалтын Пула санд хадгалдаг. Энэ сан нь гадаадын зах зээл дээр гадаад валютаар хөрөнгө оруулалт хийж, ингэснээрээ валютын ханшийн болон экспортлогч аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх дарамтыг бууруулдаг.

**Төсвийн зарлагын тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох үйл явц:** Ботсвана нь Үндэсний хөгжлийн төлөвлөгөөндөө (ҮХТ) хөгжлийн үндсэн чиглэл, бодлогын зорилтуудыг тодорхойлоод мөн улсын хөрөнгө оруулалтын төслүүдээ тусгадаг. Ингэхдээ доороос дээш чиглэсэн, мөн нөгөө талаас дээрээс доош чиглэсэн оролцоог сайн хангаж чадсан маш нарийн процесс явагддаг. Үүний хүрээнд санал болгох хөгжлийн төслүүдийг тодорхойлж хэлэлцэл хэлэлцүүлгүүд болдог. ҮХТ-нөөс гадуур ямар ч төслийг санхүүжүүлэхгүй бөгөөд харин тэргүүлэх чиглэлийн талаарх яриа хэлэлцүүлгийг засгийн газар болон иргэний нийгмийн бүх түвшинд хийдэг.

**Нэмүү өртөг бий болгох гинжин сүлжээнд тодорхой хугацааны дараа оролцож дотооддоо бий болж нэмүү өртгийг нэмэгдүүлэх:** Ботсвана нь “Алмазын хүрээ төв” болох зорилго тавьсан. Алмазыг ангилж, зэрэглэх ажлыг дотооддоо гүйцэтгэдэг болсноор улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлт болон мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлж байна. De Beers группийн (дэлхийн алмазын хамгийн том зах зээл) борлуулалтын үйл ажиллагааг одоо улсын нийслэл Gaborone-д явуулж байна. Засгийн газраас боловсруулаагүй очир эрдэнэ авдаг томоохон худалдан авагчидтай харилцаа тогтоож зүсэх болон боловсруулах дамжлагийг нутагтаа хөгжүүлэхийг дэмжихийг уриалж 3500 ажлын байрыг бий болгожээ.

Ботсванагийн хувьд байгалийн баялгаа хүртээмжтэй байдлаар ашиглан эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлд үр дүнтэй ашиглаж чадсан. Ботсвана нь тогтвортой, алхам алхмаар урагшлах хөгжлийн замаар хөгжиж байна. Шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж, хүний болон биет чадавхийг цаг хугацааны туршид бэхжүүлж ирсэн. Бодлогын гажуудлаас сэргийлж, ингэхдээ тухайлбал алмазын салбарын хувьд арилжааны гэрээ хэлэлцээрээр дамжуулан, зохицуулалтыг маш тодорхой, тогтвортой болгосон. Ил тод, урт хугацаандаа тогтвортой зохицуулалтын орчинг бий болгож үүний үр дүнд улс нь эдийн засгийн бодлогын оюуны хөрөнгийг хуримтлуулж чадсан юм.

Эх сурвалж: ["Судалгааны тайлан 3- Хүртээмжтэй өсөлтийг дэмжих нь: Байгалийн нөөц баялаг ихтэй улс орнуудын тэргүүн туршлага" 2015](#)